

(ШҮҮМЖ)

Ш. Бира

**БНМАУ-ЫН ТҮҮХ, СОЁЛ,
ТҮҮХ БИЧЛЭГИЙН АСУУДАЛД
УБ., 1977**

«БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд» эмхтгэлд академич Ш. Бирагийн монгол, орос, англи хэлээр гадаад, дотоодод урьд өмнө нийтлүүлсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, товхимол, илтгэл болон мөн шинээр бичсэн «Гүн Гомбожавын түүхийн зохиолуудын тухай», «XIII- XVII зууны монголын түүх бичлэг» болон «Монгол ба Төв Азийн орнууд» гэх зэрэг хорь гаруй зохиол орсон байна. Эдгээр бүтээл нь монголын түүх, соёл, түүх бичлэгийн олон чухал асуудлыг судлан боловсруулахад чиглэгджээ.

Академич Ш. Бира монголын эрт, дундат үеийн түүхийг судлахдаа зөвхөн монгол орны түүхээр хязгаарлалгүй харин түүнийг Төв Азийн орнуудын түүхтэй нягт холбоотойгоор шинжлэн үзэж байгаа нь арга зүйн чухал ач холбогдолтой юм. Зохиогч бичихдээ: «Одоо цагт монгол судлал улам өргөн талбарт гарч Төв Азийн ард түмнүүдийн түүх, соёлтой холбогдсон чухал чухал асуудлыг шийдвэрлэхэд идэвхтэй оролцууштай байна...Монголын судлалыг Төв Азийн соёл иргэншлийг судлах хэрэгт татан оролцуулах нь Азийн энэхүү хэсгийн ард түмнүүдийн соёл иргэншлийн нийтлэг шинж ба харилцан холбогдох тухай олон асуудлыг тайлбарлахад тус дөхөм үзүүлэх» юм гэжээ (тал 431—432) Ш. Бирагийн бичсэнчлэн чухамхүү монголын судлал, түрэгийн судлал, энэтхэгийн судлал, ираны судлал хийгээд бусад ойр төрөл ухааны уулзвар зааг дээр л бид Төв Азийн соёл иргэншлийг судлах нийтийн чармайлтандаа хамгийн дорвитой амжилт гаргаж болох билээ.

Монгол ба Төв Азийн бусад орнуудад адгуусыг гэршүүлж дараа нь мал аж ахуйг бий болгосноороо газар тариалангийн нэгэн адил өөрийн өвөрмөц соёлыг буй болгосон бөгөөд тэр нь газар тариалангийн соёлын хамт хүн төрөлхтний нийтлэг соёлын нэг чухал хэсэг яах аргагүй мөн юм,. Төв Азийн түүхийн эртний үед тэнд удам угсаатны болон соёлын хоёр үндсэн том голомт, тухайлбал өрнө зүгт энэтхэг-ираны ,дорно зүгт түрэг- монголын голомт оршин тогтнож байсан гэж Ш. Бира үзээд эрт цагт бүх газар тариалангийн улсуудын соёлоос түрэг-монголын нүүдэлчдэд илүү хялбархан дасаж зохилдсон соёл бол эцсийн эцэст энэтхэг-ираны соёлын ертөнцөөс үүсэл гаралтай соёл байсан гэсэн нь дэмжүүштэй чухал дүгнэлт болно. Зохиогч үүнийг үндэс болгон энэтхэг-төвдийн соёлын ертөнцөд монгол орны татагдан оролцох болсон үйл явц нь XVI зууны үеэс онц хурдасч, манж нар монголыг ноёрхож байсан үед ч тасалдаагүйгээр үл барам харин ч бүр хүчтэй болж, улмаар монголын нийгмийн амьдралын оюун ухааны мандалд хятадын нөлөө нэвтрэх явдлыг сарниулан үгүйсгэх хүчин зүйл болсон гэж үзжээ.

Нүүдэлчи аймгууд маш эртнээс Төв Азийн суурьшмал ард түмнүүдтэй харилцаа холбоотой байсны нөгөө нэг нотолгоо нь Кушантай

холбогдсон түүх, шашин, улс төрийн зарим уламжлал бүр сүүлийн үе болтол Монголд тасраагүй байсан явдал мөн. Кушаны үед цаашдынхаа хөгжлийг олсон «хоёр ёсон» хэмээх төрийн дээд эрхийн тухай бүддийн сургаалыг Хубилай хааны үед Монгол гүрний зохион байгуулалтын үндэс болгон уламжилж авсан бөгөөд энэ нь нүүдэлчдийн төрийн бодлогын гол зарчим болсоор XX зууны эхэн үе хүртэл үргэлжилснийг Ш. Бира цохон тэмдэглэжээ.

Монгол ба Төв Азийн орнуудын түүх, соёлын хэлхээ холбооны тухай асуудлыг нарийвчлан судлах нь европ төвийн үзэл, ази төвийн үзэл буюу бүр тодотговоос хятад төвийн үзэл зэрэг хуурмаг үзэл онолын ор үндэсгүй болохыг харуулахад зохих хувь нэмэр болох нь дамжиггүй.

Ш. Бира XIX зууны эцэс XX зууны эхний монголын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөнийг Октябрийн хувьсгал хүртэлх ба түүнээс хойшхи үе гэж үндсэн хоёр шат болгон авч үзээд, хэрэв Иран, Турк, Хятад зэрэг дорно дахины бусад улс оронд үндэсний чөлөөлөх хөдөлгөөн анх хөрөнгөтний буюу эсвэл хөрөнгөтний-ардчилсан шинжтэй гарч байсан бол 1911-1912 оны монголчуудын үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн үндсэндээ феодалын үндэсний үзлийн дор өрнөсөн ба 1921 оны монгол ардын хувьсгал нь Ази, Африк, Латин Америкийн орнуудын үндэсний-ардчилсан хувьсгалын эхлэл нь болсныг харуулсан байна.

Академич Ш. Бира БНМАУ-ын соёл, соёлын хувьсгалын хөгжлийн онол, түүхийн асуудлаар олон чухал бүтээл туурвижээ. «Монголчуудын бүддийн утга зохиолын өвийг судлах асуудалд». «Монголын автономит засгийн үед төрийн сургуулийн хэргийг хөгжүүлэх талаар авч явуулсан зарим дэвшилт арга хэмжээний тухай», «БНМАУ-ын соёлын хувьсгалыг түүхийг судлахын учир», «БНМАУ-ын соёлын хувьсгалын түүхийг судлах асуудалд», «Монголын соёлын түүхийг судлах нь» зэрэг өгүүлэлд хувьсгалын өмнөх монголын соёлын хөгжил, монголын ард түмний соёлын өв, ялангуяа БНМАУ-ын соёлын хувьсгалын түүхэн замналын тухай асуудлыг нарийвчлан судалжээ.

БНМАУ-ын соёлын хувьсгалын түүхийн асуудал бол ерөөс нэн шинэ түүх судлалын хамгийн бага судлагдсан салбарын нэг юм. Иймээс ч Ш. Бира БНМАУ-ын соёлын хувьсгалын түүхийг судлах арга зүйн асуудлуудыг нилээд бүтээлдээ хөндсөн байна. Манай орны түүхэн нөхцөлд соёлын хувьсгалын нийтлэг зүй тогтол, шинж төлөв ихээхэн өвөрмөц онцлог байдалтай илэрч гарсныг анхаарч судлахын чухлыг зохиогч онцлон тэмдэглэсэн нь зүйтэй юм.

Монголын соёлын хувьсгалын түүхэн замнал, шинж чанарыг судалсан анхны томоохон судлагааны ажлын нэг болох «БНМАУ-ын үндэсний шинэ соёлын зарим асуудал»¹ өгүүллээс эхлэн Ш. Бира өөрийн бүтээлүүд дээ БНМАУ-ын соёлын хувьсгалын ерөнхий зүй тогтол, өвөрмөц онцлог, түүний цаг хүрээ, үечлэлийн тухай асуудлаар олон чухал дүгнэлт, баримтлал дэвшүүлсэн байна.

БНМАУ-ын соёлын хувьсгалын судалгаанд Ш. Бирагийн оруулсан нэг чухал хувь нэмэр бол түүний агууллага, цаг хүрээг тодорхойлсон явдал мөн. Манай зарим судлаачид БНМАУ-д соёлын хувьсгал ялж дууссан гэх буюу соёлын хувьсгал нь коммунизм байгуулалтын үед төгсгөлийн шатандаа орно гэх зэрэг дүгнэлт хийсэн байдаг. Харин Ш.Бира социалист соёлын хувьсгалын тухай ленинч үзэл баримтлалын үндсэн дээр БНМАУ-ын соёлын хувьсгалын түүхэн туршлагыг нэгтгэн дүгнэж соёлын хувьсгалын гол агуулга, зорилт бол социалист соёлыг бүтээн байгуулах явдал мөн гэдгийг нотолж, соёлын хувьсгал нь Монгол

¹ Ш. Бира. БНМАУ-ын үндэсний шинэ соёлын тухай зарим асуудал—«Шинжлэх ухаан» 1955, № 4, 1956, № 1.

оронд ардын хувьсгал ялснаар эхлэж, социализм бүрэн ялснаар төгсөнө гэж түүний цаг, хүрээг тодорхойлсон байна.

В. И. Ленин 1921 онд Монголын засгийн газрын төлөөлөгчдийг хүлээн авч уулзаад ярилцахдаа соёлын хувьсгал бол шинэ нийгэм байгуулахын нэг чухал шийдвэрлэх нөхцөл мөн болохыг Монгол орны хувьд хамааруулан авч үзсэнийг Б. Цэрэндоржийн дургалыг задлан шинжлэсний үндсэн дээр Ш. Бира дараахи чухал дүгнэлт хийсэн байна. Ш. Бира бичихдээ: «Монгол оронд ардын хувьсгал ялснаас хойш дөнгөж гурван сар өнгөрөөд байсан үед гадаад, дотоодын дайснуудтай хийж байсан зэвсэгт тэмцэл дуусаагүй байсан чухам тэр үед орчин үеийн соёлыг хөгжүүлэх нь Монгол орны хувьд хойшлуулушгүй чухал зорилт мөнийг В. И. Ленин заасан байна» (тал 157) гэжээ.

В. И. Лениний сургаалыг үндэслэл болгож Монгол дахь соёлын хувьсгал нь ардын хувьсгалын зүй ёсны үргэлжлэл, шууд үр дагавар нь байсныг Ш. Бира нотлосон байна .

БНМАУ -ын соёлын хувьсгал нь социалист бусад оронд явагдсан соёлын хувьсгалын ерөнхий зүй тогтол, зорилт, үндсэн шинж чанарыг хадгалж байсныг Ш. Бира харуулахын хамт түүний өвөрмөц онцлог шинжийг тодорхойлоход бас анхаарал тавьжээ. Капиталист бус хөгжил, ардын хувьсгалын онцлогоос шалтгаалан БНМАУ-ын соёлын хувьсгал нь хувьсгалт-ардчилсан шинж чанартай эхлэж, улмаар тус орон социализм шууд байгуулж эхлэх шатанд дэвшихийн хамт социалист соёлын хувьсгалын үүрэг зорилтыг биелүүлэх болсон байна. Монголын соёлын хувьсгалын энэхүү туршлагыг үндэс болгон капиталист бус хөгжлийн замд орсон бөгөөд хувьсгалын өмнөх Монгол мэт хоцрогдсон орон дахь жинхэнэ социалист соёлыг бүтээн байгуулах зорилт нь нийгмийн оюун санааны амьдралын хүрээнд ардчилсан өөрчлөлтийг эхлээд хэрхэн тууштай хэрэгжүүлэхээс шууд шалтгаална гэсэн чухал дүгнэлтийг зохиогч хийсэн байна.

Социалист соёлын онол, түүхийн талаархи Ш. Бирагийн судалгааны ажлын нэг чухал чиглэл нь монголын соёлын интернационалч шинж, соёлын салбар дахь олон улсын хамтын ажиллагаа. хэлхээ холбооны тухай асуудал юм. Ийм судалгаа нь МАХН-ын XVII их хурлаас заасанчлан ЗХУ болон социалист бусад оронтой бүх талаар ойртон нягтрах явдал нийгмийн хөгжлийн бодит шаардлага болж байгаа өнөө үед улам ч чухал ач холбогдолтой болж байна.

Ш. Бира монголын марксист түүхийн ухааны чухал салбарын нэг түүх бичлэгийн ухааныг хөгжүүлэхэд багагүй хувь нэмэр болох олон бүтээл туурвижээ. Социалист орнуудад марксист түүхийн ухааны хамгийн сүүлийн үеийн шинэ салбарын нэг түүх бичлэгийн ухааныг өргөн хөгжүүлж түүхэн судалгааны онол, арга зүйг улам боловсронгуй болгох зорилготой уялдан Ш. Бирагийн эрдэм судлалын бүтээлд монголын түүх бичлэгээр туурвисан зохиол нь чухал байр эзлэдэг юм. Энэ эмхтгэлд зохиогчийн монголын түүх бичлэгийн асуудалд зориулсан «Монголын түүх бичлэг», «Монголын хуучны түүх бичлэгийн зарим нэг асуудал», «XIII—XVII зууны үеийн монголын түүх бичлэг» зэрэг бүтээлээс гадна монголын түүхийн сурвалж бичиг, түүхчдийн намтрыг түүх бичлэгийн ухааны үүднээс задлан шинжлэсэн «Шагдарын Дамдины (Алтан дэвтэр) гэдэг номын тухай», «Цагаан түүхийн зарим гол мэдээг шинжлэн, зохиосон цаг үеийг тогтоох нь», «Сүмбэ-хамба Ишбалжирын тухай зарим мэдээ», «Гунгаадоржийн (Улаан дэвтрийн) тухай зарим тэмдэг-

лэл», Гүн Гомбожавын түүхийн зохиолуудын тухай» зэрэг бүтээл орсон байна.

Зохиогч монголын түүх бичлэгийн судлагааны эдгээр бүтээлдээ монголчуудын түүхийн мэдлэг, түүх бичлэгийн ухааны өвийг үндэсний ба гадаад хэлээр бичсэн монголын түүх судлалын арвин их уг сурвалжуудад тулгуурлан Азийн ба Европ дахины түүх бичлэгийн нэрд гарсан зохиолуудтай харьцуулан судлажээ. Монголын түүхийн сурвалж бичгийг задлан шинжлэхдээ чухам хэдийд хэн зохиосон, ямар сурвалж материалыг хир зэрэг ашигласныг тодруулах, уг зохиолыг тухайн нийгэм, цаг үетэй нь холбон үзэж, монголчуудын түүхийн мэдлэг, түүх бичлэгийн хөгжилд үзүүлсэн нөлөө ба шинэ дэвшилтэт зүйлийг нь тодруулахад их анхаарал тавьжээ. Монголын ард түмэн нүүдэлч аж байдлын дунд бүтээсэн түүх бичлэгийн ихээхэн өвөрмөц өв уламжлалтайг цохон гаргаж, тэр нь дорно дахины суурьшмал ард түмнүүдийн түүхийн мэдлэгээс зарим талаар ихээхэн өөр шинж чанартайг илтгэн харуулж, нийт нүүдэлчин ард түмний түүхийн мэдлэгийг бүхэлд нь «Нүүдлийн түүх бичлэг» гэж нэрлэх сонин санал дэвшүүлж, нүүдлийн түүх бичлэгийн бие даасан хөгжлийн замыг Монголын жишээгээр судлан боловсруулжээ. Энэ нь Монголын ард түмнийг өөрийн түүх байхгүй, түүх бүтээх чадваргүй мэтээр гүтгэн үздэг «дорно дахиныг судлагч» хөрөнгөтний судлаачдын дотор өргөн тархсан гаж буруу үзэл номчирхлыг няцаахад чухал болохыг тэмдэглэх хэрэгтэй.

Зохиогч иран түүхч Джувейни, Рашид-ад-Дин хоёрын нэрд гарсан зохиолуудыг монголын уламжлалт түүх бичлэгтэй харшуулан судлаж олон сонирхолтой дүгнэлт хийсэн ба монгол түүхчдийн төвдөөр бичсэн түүхийн зохиолыг анх удаа нарийвчлан судлаж, түүх бичлэгийн ухаанд «Монголын төвд хэлт түүхийн зохиолууд» хэмээх чухал сэдвийг дэвшүүлэн тавьж монгол түүхчдээс төвд хэлээр түүхийн зохиол бүтээлээ туурвидаг биеэ даасан урсгал байсныг нээж тавьсан зэрэг нь монголын түүхийн шинжлэх ухаанд гарсан шинэ зүйл юм.

Монголын хуучны түүхчдийн ертөнцийг үзэх үзэл санаанд бүддийн сургаал хэрхэн нөлөөлсөн асуудлыг судлаж, XVI зууны хоёрдугаар хагасаас эхлэн монголын түүх бичлэг нь энэтхэг-төвдийн шашны түүхийн зохиолтой туйлын нягт холбоотой болж, Монголд феодалын ба бүддийн маягийн шинэ түүх бичлэгийн үндэс тавигдаж, энэ нь цаашид улам гүнзгийрэн бүр сүүлийн үе хүртэл хадгалагдан ирсэн болохыг харуулжээ. Гэвч бүддизм нь шарын шашны хэлбэрээр монголд өргөн хэмжээтэй дэлгэрэхдээ уугуул нутгийн түүх бичлэгийн хүчтэй өв уламжлалтай мөргөлдөж, Төвдөд тогтоосон шигээ шашин сүм хийдийн түүх бичлэгийн тийм хязгааргүй ноёрхлыг тогтоож чадаагүй гэсэн дүгнэлт хийжээ.

Монголд манжийн харийн ноёрхол тогтож байсан нөхцөлд ч монголын түүх бичлэг нь манж хятадын түүх бичлэгийн хавсарга болон хувирсангүй харин өрийн өвөрмөц шинж чанараа хадгалан үлдэж чадсан гэж үзжээ.

XVII—XIX зууны үед монголын түүх бичлэг нь урьд үеийнхээсээ нилээдгүй хөгжин дээшилж, түүх судлагааны сэдэв өргөжиж, түүх бичлэгийн арга барил нь сайжран, хэрэглэх сурвалж бичгүүдийн нэр тоо олширч, зарим талаар шүүмжлэх чиглэл буй болсон ба XX зууны эхээр түүхийг монголын төр улсын түүх, тус орны тусгаар тогтнолын ашиг со-

нирхолтой холбож үзэх явдал хүчтэй болсон зэргийг тодорхой харуулжээ.

Ш. Бира монголын түүх бичлэгийг системтэй судлаж түүний үечлэлийг: Эртнээс аваад феодализм батжиж байсан үе хүртэлх түүхийн мэдлэг (XIV зууны үе хүртэл); Хөгжингүй феодализм ба феодалын бутралын үе (XV—XVII зуун); Манжийн ноёрхол тогтож феодализм ялзран доройтсон үе (XVIII—XX зууны эхэн үе); Марксист ленинист түүх бичлэг үүсэн хөгжсөн үе (1921 —1970) гэж дөрвөн үед хуваасан нь оновчтой болжээ. Энэ үечлэлийн дөрөв дэх үе болох 1921 оны ардын хувьсгалаас хойшхи орчин цагийн монголын түүх бичлэгийг дотор нь: хувьсгалт ардчилсан шат (1921 — 1940-өөд он) марксист ленинист шат (1940—1970-аад он) гэж хоёр үндсэн шат болгож үзээд шат тус бүрд оновчтой дүн шинжилгээ хийсэн байна.

Ш. Бирагийн шинжилгээний ажлын бас нэгэн амжилт бол монголын хууль цаазны дурсгалт бичгүүдийг судласан явдал юм. «Хутагтай сэцэн хун тайжийн зохиосон нэгэн хуулийн тухай» өгүүлэлд уг хуулийн зарим хэсгийн монгол, төвд сурвалжаар уламжлагдсан хоёр эхийг харьцуулан судлаж нэгээр нь нөгөөг нь нөхвөрлөсөн бол «XVI зууны нэгэн монгол цаазны бичиг» өгүүлэлд төвд орчуулгаар уламжлагдан ирсэн уг хуулийг хожуу үеийн хууль цаазны дурсгалуудтай харьцуулан судлаж түүний гол ач холбогдол, шинж чанар, онцлогийг гаргасан нь ихэд сонирхолтой юм. «Цагаан гүүх»-ийг эс тооцвоос одоогоор олдсон монголын хууль цаазны дурсгалын хамгийн эртнийх нь болох эдгээр сурвалжийг Ш. Бира судлаад ерөөс шарын шашин дэлгэрэх болон манжийн түрэмгийлэгчдэд монгол орон эзлэгдэхээс аль өмнө Монголд хууль цаазны мэдлэг ухаан олон жилийн өв уламжлалтай байсныг нотложээ.

Академич Ш. Бирагийн монголын түүх, соёл, түүх бичлэгийн асуудлаар туурвисан бүтээлүүд нь манай ард түмний түүхэн замнал, соёлын ололтыг үгүйсгэж мушгин гуйвуулахад чиглэгдсэн хөрөнгөтний үзэл сурталчид, маоистуудын аливаа оролдлогод шийдвэртэй няцаалт өгөхөд чухал ач холбогдол үзүүлж байна.

Ч. Дашдаваа